



ДУНДГОВЬ АЙМАГ
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 09 сарын 01 өдөр

Дугаар А/165

Мандалговь

Хорио цээрийн дэглэмийг бууруулах
тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4, Үйлдвэр хөдөө аж ахуйн сайдын 2014 оны А/93 тоот тушаалын 8.3 дахь заалт, улсын мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Тус сумын Далай багт гарсан малын гоц халдварт шүлхий өвчний үеийн хорио цээрийн дэглэмийн 21 хоногийн хугацаа дуусч, вакцин тарьснаас хойш 14 хоногт дахин өвчлөл илрээгүй тул 2017 оны 09 сарын 01-нээс хязгаарлалтын дэглэмд шилжүүлсүгэй.

2.Хязгаарлалтын дэглэмийн 14 хоногийн хугацаанд малын хариулга, маллагаа, эрүүл мэндэд анхаарч, өвөлжилтийн бэлтгэл ажлыг сайтар хангахыг малчдад үүрэг болгосугай.

3.Орон нутагт болон өөр аймагт байгаа малчдын үйл ажиллагаанд байнга хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлэг үржлийн тасаг, багийн Засаг дарга, "Тэвш таван эрдэнэ", "Ирээдүй" мал эмнэлгийн удирдлагуудад даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Р.МӨНХТОГТОХ